



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр
Хурал болсон газар: Гадаад харилцааны яам

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар дор дурдсан 5 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус хуралдааны тэмдэглэлтэй гишүүд танилцаж, санал нэгтгэйгээр батлав.
2. Монголын МСС-д санхүүгийн болон худалдан авах ажиллагааны үйлчилгээ үзүүлэх Cardno Emerging Markets Ltd., Charles Kendall and Partners Ltd. компаниудтай Үндэсний ажлын албаны байгуулсан гэрээний эрх, үүргийг Монголын Мянганы сорилтын санд шилжүүлэх тухай асуудлыг Удирдах Зөвлөлийн гишүүд хэлэлцэж, Монголын МСС-д санхүүгийн болон худалдан авах ажиллагааны үйлчилгээ үзүүлэх Cardno Emerging Markets Ltd., Charles Kendall Partners Ltd. компаниудтай Үндэсний ажлын албаны байгуулсан гэрээний эрх, үүргийг Монголын Мянганы сорилтын санд тус тус шилжүүлэхийг санал нэгтэй зөвшөөрөв.
3. Удирдах зөвлөлөөс Удирдлагын багийн холбогдох албан тушаалын сонгон шалгаруулалтад сонгогдсон нэр бүхий хүмүүсийг дэмжиж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахыг зөвшөөрөх тухай асуудлыг хэлэлцэж, тэдгээртэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахыг Монголын МСС-ийн Гүйцэтгэх захиралд зөвшөөрөв.
4. Монголын МСС-ийн Удирдлагын багийн гишүүдэд олгохоор МСК-иас баталж ирүүлсэн цалингийн дээд, доод хэмжээг батлах тухай асуудлыг хэлэлцэж, УЗ-ийн гишүүдээс тодорхой санал, зөвлөмж, даалгавар өгсний үндсэн дээр батлав.
5. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчийг томилох тухай асуудлыг хэлэлцэж, Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр Захиргааны асуудал хариуцсан захирлыг томилохыг гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж батлав.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН